



# СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

# МЭДЭЭ

№46 /260/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.03.09

Цаг үе, үйл явдал

## БАЙЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЕИЙН ЗАХИРАГЧ, ШТАБЫН АЖИЛ ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛАГДЛАА



БАЙЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЕИЙН ЗАХИРАГЧ, ШТАБЫН АЖИЛ

/Гарын авлага/

Улаанбаатар хот 2021 он

ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсээс байлдааныг зохион байгуулах үеийн захирагч, штабын ажил гарын авлагыг эмхэтгэн боловсруулж Зэвсэгт хүчний офицер, ахлагч нарын оюуны хэрэгцээнд хүргээд байна. Энэхүү гарын авлага нь бидний ашигладаг үндсэн байлдааныг зохион байгуулах үеийн захирагч, штабын ажлын агуулгыг баримтлан шаардлагатай өөрчлөлтүүдийг тусгаснаас гадна олон улс тэр дундаа АНУ-ын армийн цэргийн шийдвэр гаргах ажлын практик зөвлөмжийг өгөхийг эрмэлзсэн.

Эл гарын авлага нь Зэвсэгт хүчний цэргийн удирдлагын байгууллага, нэгтгэл, анги, салбарын бүтэц, зохион байгуулалт болон тэдгээрийн удирдлагын техник хэрэгслийн хангалтын байдлыг харгалзан үндэсний цэргийн урлагийн штабын албаны дүрэм, зааврыг боловсруулах суурь өгөгдөхүүн болох юм. Түүнчлэн Зэвсэгт хүчний офицер, ахлагч нар гарын авлагыг штабын бэлтгэлдээ бүтээлчээр ашиглаж, байлдааныг зохион байгуулах үеийн штабын ажлын мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлэхийг хүсэж байна.

Дэд хурандаа А.БАТСҮХ

## ДЭЛХИЙН ХАЛУУН ЦЭГЭЭС...



Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах "UNMISS" ажиллагааны Монгол Улсын Зэвсэгт хүчний 11 дүгээр ээлжийн цэргийн багт үүрэг гүйцэтгэж байгаа Г.Лувсансамбуу нь ээждээ зориулан захидал илгээжээ. Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн Штабын бүрэлдэхүүн орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр буюу 3 дугаар сарын 8-ны өдөр Хөвсгөл аймгийн Түнэл сумын 1 дүгээр багт оршин суух түүний ээж Д.Адилбишид хүүгийнх

нь чин сэтгэлийн мэндчилгээг хүргүүлжээ. Түүний ээж Д.Адилбиш нь дэлхийн халуун цэгт энх амгаланг тогтоохоор НҮБ-ын болон Монгол улс, төр ард түмнийхээ өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгаа хурандаа О.Заяат захирагчтай мотобудлагын батальоны удирдлагууд болон даян дэлхийн энх амгалангийн үйл хэрэгт мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэж байгаа журмын нөхдөд нь чин сэтгэлийн талархал илэрхийлэн ажлын амжилт хүсэж, эрүүл энх сайхан бүхнийг ерөөсөн юм.

Хошууч Т.АНХБАЯР

## “ЭРДЭМ СУДЛАЛ-2022” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛО



ҮБХИС-ийн АТСА-аас зохион байгуулж буй “Эрдэм судлал-2022” сэдэвт эрдэм шинжилгээний хурал энэ сарын 4-ний өдөр амжилттай явагдлаа. Магистрант, докторантууд өөрсдийн сонгосон сэдвийн хүрээнд судалгааны ажлын үр дүнгээ хэлэлцүүлэх,

судалгааны ажлыг эрчимжүүлэх, арга туршлагаа харилцан солилцох боломжийг олгох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын арга зүйд суралцах зорилготой энэхүү хуралд нийт 20 гаруй илтгэлээс докторантын 5, магистрантын 3 илтгэлийг сонгож хэлэлцүүлэв.

## “ТОГТВОРТОЙ АМЬДРАЛ-АМГАЛАН ГЭР БҮЛ” ЧУУЛГАН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Зэвсэгт хүчний 325 дугаар анги Завхан аймгийн Улиастай суманд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан аймгийн Засаг даргын ивээл дор “Тогтвортой амьдрал-Амгалан гэр бүл” чуулган 2022 оны 3 дугаар сарын 3-5-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Уг чуулганд Завхан аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргал, Монголын Эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч Б.Оюунгэрэл, Монгол Улсын Ардын жүжигчин, хөдөлмөрийн баатар П.Цэрэндагва, Монгол Улсын Ардын жүжигчин Д.Мэндбаяр, Монголын эмэгтэйчүүдийн холбооны Завхан салбарын тэргүүн П.Даваахүү, Завхан аймгийн 24

сум, 115 багийн төлөөлөл, төрийн болон төрийн бус байгууллага, үйлдвэрлэгч эмэгтэйчүүд, Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн төлөөлөл 400 гаруй хүн уг арга хэмжээнд оролцлоо. Уг арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлж буй ажлын талаарх мэдээлэл, Монголын эмэгтэйчүүдийн холбооноос хэрэгжүүлж байгаа ажил, цаашдын чиг хандлага, МУАЖ, Хөдөлмөрийн баатар П.Цэрэндагва, МУАЖ Д.Мэндбаяр нар “Гэр бүлийн үнэ цэн-Хайр-Хүндлэл-Хамтын амьдрал-Амжилтад хэрхэн нөлөөлдөг вэ?”, Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил”, Монголын эмэгтэйчүүдийн холбооны Завхан салбараас “Тогтвортой ажиллагаа-Ирээдүйн үнэ цэнэ”, Завхан аймаг дахь “Хаан” банкнаас “Жижиг дунд бизнесийн зөвлөх үйлчилгээ” зэрэг илтгэл, танилцуулга, яриа, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, чуулганаас гарсан шийдвэрийг цаашид хэрэгжүүлэх, хамтран ажиллах талаар уриалга, баримт бичгийг танилцууллаа. Чуулганы эцэст “Хамтын хүч-хөгжлийн гарц” үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдахад ангиас хүн хүч, автомашин техникээр дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллалаа.

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ИВЭЭЛ ДОР ТОГТВОРТОЙ АМЬДРАЛ-АМГАЛАН ГЭР БҮЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН “ХАМТЫН ХҮЧ-ХӨГЖЛИЙН ГАРЦ” НЭГДСЭН VIII ЧУУЛГАН

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол  
Нийт: 449,914,011

Эдгэрсэн  
Нийт: 383,874,687

Нас барсан  
Нийт: 6,034,968

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН  
2,271,836 /69.8%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН  
2,173,300 /66.8%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН  
1,026,267 31,5%  
106,880 /3,3%/

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН  
8372 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ  
55

ЭДГЭРСЭН  
8198

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР

Өдөр	Шөнө
-4	-15

ӨМНӨД СУДАН

Өдөр	Шөнө
42	28

## ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,900.00	2,910.0
EUR	3,140.0	3,200.0
CNY	455.50	456.50
RUB	26.00	29.50
JPY	25.05	25.25
KRW	2.39	2.41

## ЗУРХАЙ

2022.03.09 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 7/

ХАВРЫН ДУНД ХАРАГЧИН ТУУЛАЙ САРЫН ДОЛООН УЛААН ЦАГААЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал:  
Хэл ам хэрүүл тэмцэл ирнэ  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
07.18-18.48  
Барилдлага:  
Идэр  
Шүтэн барилдлага:  
Авахуй  
Суудал: Шороо

Тухайн өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, гарагийг тахих, хагалгаа хийлгэх, гэр бүрэхэд сайн.

Мод суулгах, нарийн зөвлөгөөн хийх, улаа гаргах, хишцүү хярвас гаргахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохиистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

### Иргэн ТА

- 1 ТУНД • 12 нас хүрсэн бол, Жирэмсний хугацаа 14-36 долоо хоногийн хооронд баргаа бол,
- 2 ТУНД • 1-р тундаа хамрагдаа 21 хоногсон бол,

### ДАРХЛАА СЭРГЭЭХ НЭМЭАТ ТУНД

18 нас хүрсэн :

- Дархлаажуулалтын 2 бүрэн тунд хамрагдсан, 3 сар өнгөрсөн бол /КОВИДООР ӨВЧӨГӨЙ ҮЕ/,
- Дархлаажуулалтын 2 тунд хийгээд КОРОНАВИРУСТ ХААВАРААР ОВОООД ЭЛГЭСЭН ОДРООС ХОЙШ 21 ХОНОГ ӨНГӨРСӨН БОЛ

ХАРИН ТА: Дархлаажуулалтын 1 дэх тунд хамрагдаа ямар нэг шалтгааны уамас давтан тундаа хамрагдаагүй 3 сарын хугацаа өнгөрсөн бол 2 тунд вакцин хийгээд.

ТА ОРГИЙН ЭМНЭЭГТЭЭ ОЧИЖ ВАКЦИНДАА ХАМРАГААРАЙ

